



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/764

Эрдэнэт


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6/а,л/, 29.2, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Олон улсын хүний эрхийн өдрийг угтаж аймгийн хэмжээнд төрийн байгууллага, иргэдийг оролцуулан хүний эрхийн сургалт, нөлөөллийн олон талт арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардалд шаардагдах 3000000 /Гурван сая/ төгрөгийг Орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний зардлын Хүний эрхийг хангах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2018 оны
12 дугаар сарын 26-ны өдрийн
11/76/4 дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөгөөр/	Нийт дүн /төгрөгөөр/
1	Хүний эрхийн чиглэлээр иргэд, төрийн байгууллагуудад сургалт зохион байгуулах	1	300000	300000
2	ЕБС-уудын дунд "Хүний эрхийн театр" арга хэмжээг зохион байгуулах	1	950000	950000
2	Хууль, эрх зүйн баримт бичиг, гарын авлага хэвлүүлэх тараах	2500	700	1750000
Нийт				3000000